

“МОНГОЛБАННЕР” ХК

2010 оны 05 сарын 25 өдөр

Дугаар: 11

УБ хот

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

Хурлын материал хүргүүлэх тухай

“Монголбаннер” ХК нь /Регистрийн дугаар: 2030136/ 2010 оны 04 сарын 28 өдөр Улаанбаатар хотноо хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаа зарлан хуралдуулсан болно.

Хувьцаат компанийн хувь нийлүүлэгчдийн хурлын зар мэдээг хүргэх тухай журмын 2.12-т заасны дагуу тус компанийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын материалыг хүргүүлж байгааг хүлээн авна уу.



A handwritten signature in black ink.

Д.НАНЖИНЧИМЭГ

“МОНГОЛБАННЕР” ХК

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо 2010.04.28

Дугаар: 01

Улаанбаатар хот

Xурал хүчин төгөлдөрт тооцох тухай

“Монголбаннер” ХК-ийн Хувь нийлүүлэгчдийн 2010 оны 04 сарын 28-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын ирцийн мэдээг үндэслэн **ТОГТООХ НЬ**:

2010 оны 04 сарын 28 өдөр хуралдсан “Монголбаннер” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хуралд саналын эрхтэй 336 624 ширхэг хувьцаа эзэмшсэн хувь нийлүүлэгчид оролцсон нь компанийн нийт 374 018 ширхэг хувьцааны 90 хувь тул Компанийн тухай Монгол Улсын хуулийн 70.1 дүгээр зүйлийг үндэслэн “Монголбаннер” ХК-ийн Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцон хуралдуулсугай.



Ч.ЗУЛЦЭЦЭГ

“МОНГОЛБАННЕР” ХК

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо: 04.04.28

Дугаар: 02

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 60.4, 63.1.15 дахь заалт, “Монголбаннер” ХК-ийн 2010 оны 04 сарын 28 өдрийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хуралд оролцгосдын дийлэнх олонхийн саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Монголбаннер” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлыг удирдах даргаар Б.Ононг сонгон ажилуулсугай.



Б. Нарангэрэл

В.НАРАНГЭРЭЛ

“МОНГОЛБАННЕР” ХК

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо: 2010.04.28

Дугаар: 03

Улаанбаатар хот

Тогтоол батлах тухай

2010 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Гранд Оффис Төвийн хурлын танхимд хуралдсан ““Монголбаннер” ХК-ийн Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын Тооллогын Комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Компанийн 2009 оны Санхүүгийн тайланг хэлэлцэн баталсугай.
2. Компанийн 2010 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, үйл ажиллагааг өргөжүүлэн тогтвортой ажиллуулах, хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх, нэмэлт хувьцаа гаргах талаар хуралд хэлэлцсэн асуудлыг бүрэн дэмжиж байгаа тул түүнийг батлан цаашид хэрэгжүүлэн, үйл ажиллагаагаа өргөжүүлэн ашигтай ажиллах, холбогдох эрх бүхий байгууллагад хүсэлт гарган шийдвэрлүүлэх эрхийг Гүйцэтгэх Захирал /Д.Нанжинчимэг/-д үүрэг болгосугай.
3. Компанийн оноосон нэрийг цаашид явуулах үйл ажиллагаатай холбогдуулан “Говьфайнэншл групп” ХК болгон өөрчлөхийг бүрэн зөвшөөрөн, холбогдох эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэн зөвшөөрөл авч компанийн баримт бичигт өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.
4. Компанийн Хянан Шалгах Зөвлөлийн 2009 оны үйл ажиллагааны үр дүнгийн талаарх дүгнэлтийг Хавсралтаар баталсугай.
5. Компанийн хувь нийлүүлэгчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай журам, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам, Мэдээллийн үйл ажиллагааны журам, Дотоод хяналт шалгалтын журам, Ногдол ашгийн журамуудыг хавсралтуудаар баталсугай.
6. Уг журмуудад нэмэлт өөрчлөлт хийх, шинэчлэн найруулж батлах эрхийг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгосугай.
7. Эдгээр журмуудын хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж, 2010 оны 04 сарын 29-ны өдрөөс эхлэн мөрдөн ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д.Нанжинчимэг/-д үүрэг болгосугай.



Б.ОНОН

“МОНГОЛБАННЕР” ХК

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо 2010.04.28

Дугаар: 01

Улаанбаатар хот

Эхэлсэн цаг: 18 цаг 20 минут.

Дууссан цаг: 19 цаг 40 минут.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2009 оны санхүүгийн тайлан,
2. 2010 оны ажлын төлөвлөгөө, үйл ажиллагааг өргөжүүлэх талаарх асуудал,
3. Компаний нэрэнд өөрчлөлт оруулах асуудал
4. Хянан шалгах зөвлөлийн тайлан,
5. Бусад (ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Мэдээллийн үйл ажиллагааны журам, Дотоод хяналтын журам, Ногдол ашиг тараах журам)

Хурлыг тус компаний гүйцэтгэх захирал Д.Нанжинчимэг хурлыг нээв.

Д.Нанжинчимэг:

- Хуралд хүрэлцэн ирсэн хувь нийлүүлэгчиддээ баярлалаа. Хурлын ирцийг танилцуульяа. Компанийн нийт 374 624 ширхэг хувьцааны 90 % буюу 336 624 ширхэг хувьцааг эзэмшигчид ирсэн тул хурлыг хүчинтэй тооцож эхлүүлье.

Хувь нийлүүлэгчдийн саналаар тус компанийн ТУЗ-ийн гишүүн Б.Ононг Хурлын даргаар томилов.

Б.Онон (хурлын дарга)

- Хурлын дэгийг танилцуульяа. Хурал хэлэлцэх асуудлын жагсаалтын дагуу явагдана. Хэлэлцсэн асуудлын төгсгөлд асуулт хариулт явагдах 1 минутын хугацаа өгнө. Компаний 2009 оны санхүүгийн тайланг гүйцэтгэх захирал Д.Нандинчимэг танилцуулна.

Д.Нанжинчимэг:

- Манай компани Монгол Шинэс ХК нэртэй байсан ба 2009 оны 8 сарын 28-ний өдрийн Хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлаараа компаний дүрэмд өөрчлөлт оруулж, үйл ажиллагааг сэргээх төслийг баталж, удирдлага зохион байгуулалтанд өөрчлөлт оруусныг та бүгд мэдэж байгаа. Мөн хурлаар компанийн нэрийг Монгол Баннер ХК болгон өөрчлөн, Улаанбаатар хотод үйл ажиллагааг эрхлэх шийдвэрийн хувь нийлүүлэгчид санал нэгтэйгээр баталсан.

Ийнхүү Санхүүгийн Зохицуулах Хорооны 2009 оны 09 сарын 10-ний өдрийн 186-р тогтоолоор тогтоолоор Монгол Шинэс ХК-ний үнэт цаасны арилжааг сэргээнээр тус компаний үйл ажиллагааг

идэвхжүүлэх ажлын эхлэл албан ёсоор тавигдсан. Тухайн үед үйл ажиллагаа, арилжаа дөнгөж сэргээгдсэн байсан тул бид албан ёсны бичиг баримтын шаардлагатай өөрчлөлтүүд хийх болон Орхон аймгаас Улаанбаатар хотруу шилжиж ирэх бүх үйл явц зэрэг гадны хүчин зүйлийн хамааралтай нөхцөлөөс нилээд хугацаагаар үйл ажиллагаа явуулах боломжгүй байдалд байсан. Иймд тухайн онд тогтмол гардаг зардал болон баримт бичгийн өөрчлөлтэй холбоотой зардлаас гадуур санхүү тайлан бүртгэлд томоохон өөрчлөлт ороогүйг энд дурдья. Ингээд 2009 онд мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл 123 743 911 төгрөг, үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ нь 123 583 264 төгрөг, мөнгөн зардал 6 316 736 төгрөг байсан./санхүүгийн тайланг хавсаргав/

Асуулт:

Хувь нийлүүлэгч Б.Уянга:

- Санхүүгийн тайланг олон нийтэд юмуу хувьцаа эзэмшигчдэд урьдчилан танилцуулсан уу. Миний хувьд энэ онд үйл ажиллагаа явуулаагүй байгаа байдал цаашид компаний ирээдүйд ямар нэг байдлаар нөлөөлөх вий гэж болгоомжилж байна. Энэ тал дээр дэлгэрэнгүй тайлбар сонсмоор байна.

Д.Нанжинчимэг:

- Бид өдөр тутмын сонинд тайланг хуулийн хугацаанд нь хэвлүүлсэн байгаа. Харин үйл ажиллагаа явуулаагүй байдал биднээс шууд хамааралгүй нөхцөл байдал байсан учир бид цаашдаа хуулийн дагуу бүх баримт бичгийн бүрдүүлэлт дууссан үед үйл ажиллагаагаа шинэ төслийн дагуу хэвийн үргэлжлүүлэх болно. Ямар нэг сөрөг үр дагаварт хүргэхгүй талаас бид бүх арга хэмжээг авна.

Б.Онон (хурлын дарга):

2010 оны үйл ажиллагааны төслийг ТҮЗ-ийн дарга У.Болдбаатар танилцуулна.

У.Болдбаатар:

- 2010 онд бид холбогдох баримт бичгийн өөрчлөлт, Улаанбаатар хотод шилжих зэрэг ажлуудыг бүрэн эцэслэн Монголын Хөрөнгийн Бирж дээр шинэ нэрээр хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтээ тавих ба нэмэлт хувьцаа гаргах талаар судалгаа явуулахаар төлөвлөж байна. Та бүхэнд тараасан бизнес төлөвлөгөөтэй танилцсан байх гэж бодож байна. Уг төлөвлөгөөний хэрэгжилтийг жилийн эцэст дүгнэх болно.

Асуулт хариулт.

Хувь нийлүүлэгч С.Батхишиг:

- Нэг санал байна. Нэмэлт хувьцаа гаргах нь зүйтэй гэж үзэж байна. Цаашид үйл ажиллагаа нилээд өргөжих талаар бизнес төлөвлөгөөнд дурьсан байна. Иймд нэмэлт хөрөнгө зайшгүй шаардлагатай.

Б.Онон (хурлын дарга):

- Хурлаар хэлэлцэх 3 дахь асуудал бол компанийн нэрийг Монгол Баннер ХК-с Гобьфайнэншл групп ХК болгон өөрчлөх саналыг ТҮЗ-ийн зүгээс гаргаж байгаа. Энэ нэрийг өөрчлөх болсон шалтгаан нь цаашид эрхлэх үйл ажиллагааны чиглэлд нийцүүлэх зорилгоор хийж байгаа болно. Манай компани цаашид.govийн бүсийн хөгжлийн төслүүдэд оролцох зорилттой байгаа ба шинээр эхлэх үндсэн үйл

ажиллагааг энэ бүсэд төвлөрүүлэх зорилттой байгаа тул нэрэнд энэхүү өөрчлөлтийг хийж байгаа болно. Мөн хөрөнгө оруулахаар тохиролцож байгаа гадаадын хөрөнгө оруулагчид болон сангүүд компанийн нэрээ өөрчилөх санал тавьсаны өөрчилөхөөр санал оруулж байна. Энэ дээр та бүхний санал, дэмжлэгийг сонсъё.

Хувь нийлүүлэгч: Б.Уянга

- Компанийн 2009 оны тайлан болон 2010 оны төлөвлөгөөтэй танилцаа. Энэ үйл ажиллагааг сэргээж байгаа явдалд баяртай байна. Дэмжиж байна. Нэмэлт хувьцаа гарган хувьцаа эзэмшигчдийн тоог нэмэх асуудал нь зүйтэй гэж дэмжиж байна. Компанийн нэрийг өөрчлөх тал дээр санал нэг байна. Одоо байгаа энэ Монгол Баннер гэж нэр миний хувьд яг тийм сайн ойлгомжтой нэр биш гэж шүүмжилмээр байна.

Хувь нийлүүлэгч Б.Онон:

- Дахин нэр өөрчлөгдхөөр өмнөх нэр хаяг болон шилжих хөдөлгөөнтэй асуудал шиг хугацаа алдах ажил цалгардах зүйл гарах юм биш биз?
- Д.Нанжинчимэг:
түрүүнд шилжих хөдөлгөөн дээр нилээд удсан. Энэ удаад бол бид нэгэнт Улаанбаатар хотод харьяалагдах болсон тул нэрийн өөрчлөлттэй асуудалтай хамаатай материалыа холбогдох газруудад хүргүүлэн хүсэлтээ тавьсан нөхцөлд энэ асуудал тохирох журмын дагуу шийдэгдэнэ гэж бодож байна.

Хэлэлцэж буй 3-р асуудлаар дахин асуулт санал гараагүй тул дараагийн асуудалд оров.

Хянан шалгах зөвлөлийн гишүүн Б.Бат-Орших тус зөвлөлийн тус компанийн 2009 оны үйл ажиллагааны үр дүнд өгсөн дүгнэлтийг уншиж танилцуулав. Дүгнэлттэй холбоотой санал асуулт гараагүй тул хурлын дэгийн дагуу дараагийн асуудалд оров. /Хянан шалгах зөвлөлийн тайланг хавсаргав/

Б.Онон (хурлын дарга):

- ингээд хурлын дэгийн дагуу бусад асуудалдаа орьё. Бид та бүхэнд шинээр батлах журмуудыг тараасан байгаа. Үүнд: Компаний хувь нийлүүлэгчдийн хурлыг зарлан хуралдуулах журам, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Мэдээллийн үйл ажиллагааны журам, Дотоод хяналтын журам, ногдол ашгийн журам гэсэн нийт 5 журмыг энэхүү хуралдаанаар батлах асуудалыг хэлэлцье. Та бүхэнд ямар нэг санал дүгнэлт байна уу? Мөн энэхүү журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай нөхцөлд ТУЗ гүйцэтгэж байх эрхийг олгох саналтай байна.

Шинээр батлах журмууд дээр нийт хуралд оролцогчдоос ямар нэг санал, асуулт гараагүй тул дээрхи журмуудыг батлах санал хураалт явуулж, 100%-ийн саналаар батлан нэмэлт өөрчлөлт оруулах эрхийг хувь нийлүүлэгчдийн олонхийн саналаар ТУЗ-д шилжүүлэв.

Монгол Баннер ХК-ийн 2010 оны 04 сарын 28-ний өдрийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлан дагуу **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ**:

- Компанийн 2009 оны санхүүгийн тайланг батлах,
- Компанийн 2010 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, үйл ажиллагааг өргөжүүлэн тогтвортой ажиллуулах, хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх, нэмэлт хувьцаа гаргах талаар хуралд хэлэлцсэн асуудлыг бүрэн дэмжиж байгаа тул түүнийг батлан цаашид хэрэгжүүлэн, үйл ажиллагаагаа өргөжүүлэн ашигтай ажиллах, холбогдох эрх бүхий байгууллагуудад хүсэлт гарган шийдвэрлүүлэх эрхийг Гүйцэтгэх захирал / Д.Нанжинчимэг /-д үүрэг болгох,
- Компанийн оноосон нэрийг цаашид явуулах үйл ажиллагаатай холбогдуулан “Говьфайнэншл групп” ХК болгон өөрчлөхийг бүрэн зөвшөөрөн, холбогдох эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэн зөвшөөрөл авч компанийн баримт бичигт өөрчлөлт оруулах.
- Компанийн Хянан Шалгах Зөвлөлийн 2009 оны үйл ажиллагаавы үр дүнгийн талаарх дүгнэлтийг хавсралтаар батлах,
- Компанийн хувь нийлүүлэгчдийн хурлыг зарлан хуралдуулах журам, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам, Мэдээллийн үйл ажиллагааны журам, Дотоод хяналт шалгалтын журам, Ногдол ашгийн журмуудыг хавсралтуудаар батлах,
- Уг журмуудад нэмэлт өөрчлөлт хийх, шинэчлэн найруулж батлах эрхийг компанийн ТУЗ-д олгох,
- Эдгээр журмуудын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д.Нанжинчимэг /-д үүрэг болгох,

Хурал 19цаг 40 минутанд өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ХӨТӨЛСӨН



Б.ОНОН

Д.НАНЖИНЧИМЭГ



“Монголбаннер” ХК-ийн 2010 оны 4 дүгээр сарын 28-ний
өдрийн хувь нийлүүлэгчдийн хурлын
тогтоолын хавсралт.

**“МОНГОЛБАННЕР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ
ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмаар хувь нийлүүлэгчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлах, хуралдуулах, хувь нийлүүлэгчдэд мэдээлэл хүргэх, хурлын бүрэн эрх, хурлаар хэлэлцэх асуудалд санал оруулах хувь нийлүүлэгчдийн эрхийг хэрэгжүүлэх журам, хурлын дэг, хурлын шийдвэрийг баталгаажуулах журам зэргийг зохицуулна.

1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн үйл ажиллагаа, ололт амжилт, цаашдын төлөвлөгөөний талаар хувьцаа эзэмшигчиддээ мэдээлэх, компанийн үйл ажиллагаатай холбоотой чухал асуудлыг хэлэлцэн, шийдвэр гаргах зорилготой байдаг.

Энэ хурал нь жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьд компанийн үйл ажиллагааны талаар бүрэн мэдээлэл олж авах, удирдлагад асуулт тавих боломж олгодог. Хуралд оролцсоноор хувьцаа эзэмшигч нь компанийн удирдлагад оролцох эрхээ хэрэгжүүлдэг.

Хувьцаа эзэмшигчдийнхээ итгэлийг хүлээхийн тулд хурлыг бүх хувьцаа эзэмшигчдэд тэгш хандах зарчмаар зохион байгуулах бөгөөд хувьцаа эзэмшигч бүр хуралд оролцох боломжийг хангах нь ТУЗ-ийн үүрэг байна.

**Хоёр. Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурал хуралдуулах шийдвэр гаргах,
хурлын зар мэдээг хүргэх**

2.1. Сонирхсон хувьцаа эзэмшигч хурлын зар мэдээ, гаргах шийдвэрийн төсөл, бусад мэдээлэлтэй танилцах боломж олгож, хурлын бэлтгэлийг сайтар хангах, хувьцаа эзэмшигчдэд хурлаар хэлэлцэх асуудлаар саналаа боловсруулах хугацаа олгон, хуралд оролцох эрхтэй этгээдүүдийн талаар мэдээлэл өгч, бусадтайгаа хэлэлцэх асуудлын талаар санал солилцох боломж олгох асуудлыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцна.

2.2. Хувьцаа эзэмшигчдэд хүргэх хурлын зар нь хуралд ямар хэлбэрээр оролцоо /биечлэн, саналын хуудсаар саналаа хүргэх, итгэмжлэгдсэн этгээдээр төлөөлүүлэн/ шийдвэрлэхэд шаардлагатай мэдээлэл агуулсан байна.

2.3. Хурлын өмнө хуульд заасан хувьцаа эзэмшигчдэд заавал танилцуулах бичиг баримтыг бүрэн бэлдсэн байна. Эдгээр бичиг баримтад тусгасан мэдээлэл нь хувьцаа эзэмшигчид үндэслэлтэй шийдвэр гаргах боломж олгохуйц байхаас гадна санал хураалт явуулах журмыг багтаасан байх ёстой. Мөн хувьцаа эзэмшигчид хурлаас гарах шийдвэрийн төсөл болон дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцах газар болон санал өгөх хуудсыг хүлээн авч болох газар, хувьцаа эзэмшигчдийн санал авах, мэдээлэлтэй танилцах журмыг зөрчсөн тухай санал гомдлыг хүлээж авах этгээдийн харилцах утас, хаяг, саналын хүлээж авах сүүлчийн хугацааг тодорхой заасан байна.

2.4. Хуралд оролцох эрх бүхий этгээдийн нэрсийн жагсаалттай танилцснаар жижиг хувьцаа эзэмшигчид хоорондоо холбогдож, хурлаар хэлэлцэх гэж буй асуудлын талаар саналаа солилцох, хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх талаар хамтран санал боловсруулах боломжтой болно. Компани нь хурлын зар хүргэж эхэлсэн өдрөөс эхлэн хурал хуралдах

хүртэл хугацаанд хуралд оролцох эрх бүхий этгээдийн нэrsийн жагсаалттай танилцах боломжийг олгоно.

2.5. Сонирхсон этгээдэд хувьцаа эзэмшигчдийн нэrsийн жагсаалттай танилцах боломжийг олгох эсхүл тухайн этгээд уг жагсаалтад байхгүй тухай тодорхойлолтыг гаргаж өгнө. Энэ нь хувьцаа эзэмшигч хуралд оролцоход саадгүй гэдгээ мэдэх, өөртэй нь холбоотой мэдээлэл үнэн зөв гэдгийг баталгаажуулах, бүртгэлд нэр нь байхгүй, эзэмшиж байгаа хувьцааны тоо, хаяг, регистрийн дугаар нь буруу ташаа байгаа тохиолдолд шалтгааныг тодруулж, жагсаалтад бүртгүүлэх, мэдээллийн алдааг залруулах боломж олгоно.

2.4. Хэрвээ хувьцаа эзэмшигч электрон шуудангийн хаягаа нарийн бичгийн даргад өгсөн бол цахим хэлбэрээр хурлын зар, холбогдох мэдээллийг хүргэнэ.

2.5. Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлыг жил бүрийн 4 дүгээр сарын сүүлчийн Бямба гарагийн 11 цагаас хуралдуулна.

2.6. ТУЗ нь жил бүрийн 3 дугаар сарын 10-ний дотор хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын хуралдуулах тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

2.7. Хурал хуралдуулах тухай шийдвэрт хурлыг хуралдуулах газар, огноо, хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, асуудал бүрээр гарах шийдвэрийн төсөл, ТУЗ болон хяналтын зөвлөлд нэр дэвшигчдийн жагсаалт зэргийг багтаасан байна.

2.8. Ээлжит хурал хуралдуулах шийдвэр гарсны дараа хурал хуралдахаас 30-аас доошгүй хоногийн өмнө олон нийтийн мэдээллийн хэрэгсэл үүнд өдөр Өнөөдөр сонин, Өдрийн сонин, Зууны мэдээ, олон нийтийн телевиз зэргээр хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэх бөгөөд, компанийн веб хуудсанд тавьсан байна.

2.9. Хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргүүлнэ. Үүнд хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төслөөс гадна, санал авах хуудсыг хүргүүлнэ.

Гурав. Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаар заавал хэлэлцэх асуудал

3.1. Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг заавал хэлэлцэнэ.

3.1.1. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах

3.1.2. хяналтын зөвлөлийн тайланг хэлэлцэж батлах

3.1.3. компанийн эрхлэн явуулсан үйл ажиллагааны танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүн, бүтэц зохион байгуулалт, түүний өөрчлөлт, компанийн хөрөнгийн өөрчлөлтийн тухай тайлан,

тайлангийн хугацаанд эрх бүхий албан тушаалтанд олгосон шагнал урамшууллын тайлан

3.1.4. ирэх санхүүгийн жилийн үндсэн зорилт, үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөөг хэлэлцэж батлах

3.1.5. ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн санал, хуваарилахгүй гэсэн санал оруулж байгаа бол түүний үндэслэл, эдийн засгийн тооцоо, судалгаа

3.1.6. төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал

3.1.7. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудлууд

Дөрөв. Хувьцаа эзэмшигчдэд заавал танилцуулах мэдээлэл

4.1. Хурлыг үр дүнтэй болгох, хувьцаа эзэмшигчдийн оролцоог идэвхжүүлэх зорилгоор шинжилгээ судалгааны болон хэвлэлийн мэдээлэл, үүний дотор компанийн үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандсан мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулна.

4.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан

4.3. Компанийн санхүүгийн тайлангийн талаарх гүйцэтгэх удирдлагын тайлан, түүнд хийсэн дүн шинжилгээ

4.4. Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт

4.5. Компанийн ТУЗ-ийн тайлан, ТУЗ-ийн гишүүн бүрийн үйл ажиллагааны талаарх дүгнэлт

4.6. Хяналтын зөвлөлийн тайлан

4.7. Ирэх санхүүгийн жилийн төлөвлөгөө, төсөв, үндсэн зорилт

4.8. Компанийг өөрчлөн байгуулах асуудал хэлэлцэх тохиолдолд компанийг өөрчлөн байгуулах үндэслэл, төсөл, жилийн тайлан, өөрчлөн байгуулагдсан тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрхэн хэрэгжүүлэх болон компанийг өөрчлөн байгуулахад оролцож буй талуудын сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан

4.9. ТУЗ болон хяналтын зөвлөлд нэр дэвшигчдийн товч намтар, ажлын туршлага, мэдлэг болосрол, ур чадварын талаарх мэдээлэл

4.10. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн санал, хуваарилах бол нэгж хувьцаанд хуваарилахаар санал болгож буй ногдол ашгийн хэмжээ, түүнийг тогтоосон үндэслэл тооцоо, хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол түүний үндэслэл, тооцоо

Тав. Хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэх асуудалд санал авах журам

5.1. Хувь нийлүүлэгчдийн хуралд хэлэлцэх асуудалд санал оруулах, ТУЗ-ийн болон хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигч жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор саналаа ТУЗ-ийн нарийн бичгийн даргад бичгээр ирүүлнэ.

5.2. Саналд хэлэлцүүлэхээр санал болгож буй асуудлын томъёолол, уг асуудлыг хэлэлцүүлэхээр оруулж байгаа шалтгаан, санал ирүүлсэн хувьцаа эзэмшигчийн нэр овог, хаяг, эзэмшиж байгаа хувьцааны тоо төрөл зэргийг заасан байна.

ТУЗ-ийн болон хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж байгаа бол нэрийг нь дэвшүүлж байгаа этгээдийн овог нэр, компанийн ТУЗ-ийн гишүүнд тавих шаардлагыг хэрхэн хангаж байгаа тухай мэдээлэл, түүнийг нотлох баримт, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүний алинд нь нэр дэвшүүлж байгаа тусгасан байна. Саналд компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 1-р хавсралтаар баталсан “Нэр дэвшигчийн зөвшөөрөл”, 2-р хавсралтаар баталсан “Нэр дэвшигчийн анкет” зэргийг хавсаргасан байна.

5.4. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хувьцаа эзэмшигчээс ирүүлсэн саналыг хүлээн аваад ТУЗ-ийн даргад шилжүүлнэ. Шилжүүлэхдээ санал ирүүлсэн этгээд нь компанийн хувьцаа эзэмшигч мөн эсэх, түүний бусад мэдээлэл бодитой эсэх, хэлэлцүүлэхээр санал болгож байгаа асуудалд нь хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах эсэх, ТУЗ, хяналтын зөвлөлд нэр дэвшүүлж байгаа бол нэр дэвшигч нь компанийн ТУЗ-ийн гишүүнд

тавих шаардлагыг хангаж байгаа эсэх, холбогдох мэдээллийг бүрэн ирүүлсэн эсэх тухай дүгнэл гарган танилцуулна.

5.5. ТУЗ-ийн дарга нь тухайн асуудлыг хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах боломжтой гэж үзвэл холбогдох бэлтгэлийг хангуулан хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар ТУЗ-ийн хуралд оруулна. Боломжгүй гэж үзвэл үндэслэл тайлбараа санал гаргасан хувьцаа эзэмшигчид санал ирүүлснээс хойш ажлын 7 хоногт багтаан хүргүүлнэ.

ТУЗ-ийн дарга нь зөвхөн дараах нөхцөл саналыг хүлээн авахаас татгалзана.

5.5.1. ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшүүлэхээр санал гаргагч нийт гаргасан энгийн хувьцааны 10-аас бага хувийг эзэмшдэг;

5.5.2. энэ журмын 5.2-т заасан мэдээллийг бүрэн тусгаагүй.

5.5.3. санал нь хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхэд хамаarahгүй асуудал байсан эсхүл хурлаар хэлэлцэх асуудалд орсон асуудал байсан

5.6. Санал гаргасан хувьцаа эзэмшигч саналыг хүлээн аваагүй тухай гомдлоо хяналтын зөвлөлд гаргана. Хяналтын зөвлөл гомдлыг хүлээн аваад саналыг хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэх ёстой гэж үзвэл ТУЗ-ийн хуралд оруулж хэлэлцүүлнэ.

Зургаа. Хурал хуралдуулах, хурлын дэг

6.1. Хурлыг компанийн ерөнхий захиргаа оршин байгаа газрын хурлын зааланд хуралдуулна.

6.2. Хурлын бэлтгэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцан хангах бөгөөд хурал зохион байгуулах комисс бүхий л талаар туслалцаа үзүүлнэ.

6.3. Хурал хуралдах цаг болоход хурлын байр, техник хэрэгсэл, ширээ сандал, санал авах хуудас, хувьцаа эзэмшигчдэд танилцуулах материал, зэргийг хангалттай хэмжээгээр бүрэн бэлдсэн байна.

6.4. Хуралд оролцохоор ирсэн хувьцаа эзэмшигчдийг бүртгэх, тараах материал болон саналын хуудсыг тараан өгөх ажиллагааг хурал зохион байгуулах комиссын гишүүд хариуцан гүйцэтгэнэ. Ирсэн гишүүн бүрийн бүртгэлд байгаа нэр хаяг, регистрийн дугаар зөв эсэхийг тодоруулан холбогдох залруулга хийхийн зэргэцээ тэдний мэйлийн хаягыг тэмдэглэн авч, хүргэх мэдээллийг мэйлээр авах саналтай эсэхийг тэмдэглэн авсан байна.

6.5. Хуралд оролцохоор ирсэн хувьцаа эзэмшигч нь иргэний үнэмлэх, жолооны үнэмлэх зэрэг тухайн хүнийг тодорхойлох бичиг баримттай байна.

Өөрийн гэр бүлийн гишүүд юмуу бусад этгээдийг төлөөлөн итгэмжлэлээр оролцож байгаа бол нэг гэр бүлийн гишүүд болохыг нотлох гэр бүлийн баталгаа хүүхдийн гэрчилгээ, иргэний үнэмлэх зэрэг бичиг баримттай ирнэ. Харин гэр бүлийн гишүүдээс өөр этгээдийг төлөөлж байгаа бол заавал нотариатаар гэрчлүүлсэн итгэмжлэхтэй байна. Өөр этгээдийн саналыг саналын хуудсаар өгч байгаа бол саналын хуудсыг тухайн этгээд өөрөө бөглөснийг гэрчлэн БДК тэмдэг дарсан байна. Хурлын тооллогын комиссын протоколд хэн хэнийг төлөөлөн саналын хуудсыг авч ирснийг болон хэн хэнийг төлөөлөн итгэмжлэлээр болон гэр бүлийн гишүүн хэн хэнийг төлөөлөн оролцсоныг заавал тэмдэглэнэ. Хуралд оролцож байгаа 3-аас илүү гишүүн гэрчилсэн тохиодолд биеийн байцаалтаа орхиж ирсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцуулна. Хурал даргалагч нь

хуралд ирсэн хувьцаа эзэмшигчийг аль болох оролцуулах боломжтой арга хэмжээ авах Үүрэгтэй.

6.6. Хурал эхлэхэд тооллогын комисс хуралд хичнээн саналын эрх бүхий хувьцааг эзэмшиж байгаа хэдэн хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирснийг мэдэгдэх бөгөөд нийт саналын эрхийн хэдэн хувийг эзэмшигчид хүрэлцэн ирсэн / биеэр болон саналын хуудсаар/ тохиолдолд хурлын ирц хүчин төгөлдөр болсон гэж үзэж хурлыг эхлүүлнэ.

6.7. Хурлыг ТУЗ-ийн дарга удирдана. ТУЗ-ийн дарга эзгүй бол ТУЗ-өөс томилсон аль нэг гишүүн удирдана.

6.8. Хуралд ТУЗ-ийн бүх гишүүд, гүйцэтгэх удирдлагын компанийн дүрмээр эрх бүхий албан тушаалтан гэж тодорхойлсон бүх албан тушаалтууд болон ТУЗ, хяналтын зөвлөлд нэр дэвшиж байгаа бүх хүмүүс оролцож, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулна.Хурал ирээгүй албан тушаалтын ирээгүй шалтгааныг ТУЗ-ийн дарга танилцуулна.

6.19. Хурлаар хэлэлцэхээр товлосон бүх асуудлыг танилцуулж дууссаны дараа хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн асуултад холбогдох албан тушаалтан тодорхой хариулт өгнө. Хурлын явцад тодорхой хариулт өгөх боломжгүй асуултыг протоколд тэмдэглэн, хариултыг бэлдэн хувьцаа эзэмшигчийн хаягаар хүргүүлэхийг хэн хариуцан, хэдийд хүргэхийг хувьцаа эзэмшигчид мэдэгдэнэ.

6.10. Асуулт хариулт дууссаны дараа хувьцаа эзэмшигчдийн санал, хүсэлтийг сонсоно. Асуулт хариулт, санал хүсэлт бүрийг хурлын протоколд дэлгэрэнгүй тэмдэглэнэ.

6.11. Санал хүсэлт нь өмнөх хувьцаа эзэмшигчдийг давтсан, хэт нуршуу байгаагаас бусад тохиолдолд бүрэн хэлэх боломж олгоно.

6.12. Хурал даргалагч нь өөрийн санал бодлыг тулгах зэргээр хувьцаа эзэмшигчдэд ямар нэгэн дарамт үзүүлэхийг хориглоно.

6.13. Хурлаар хэлэлцэх асуудал дууссаны дараа саналын хуудсыг бүрэн хураан авч, хурлаас томилогдсон тооллогын комисс саналыг тоолно. ТУЗ-ийн гишүүн сонгохоос бусад асуудлыг хууль болон дүрэмд заасны дагуу саналын дийлэнх, юмуу олонхоор, харин ТУЗ-ийн ердийн гишүүн сонгох асуудлыг кумулятив аргаар, хараат бус гишүүн сонгох асуудлыг санал өгсөн гишүүн бүр нэг саналтай оролцож, саналын олонхиор шийдвэрлэнэ.

6.14. Хурал хуралсанаас хойш ажлын 5 хоногийн дотор хурлын тэмдэглэл, шийдвэрийг албажуулан гаргаж, ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж, компанийн тэмдэг дарж баталгаажуулан хадгалах бөгөөд нэг хувийг Нийслэлийн мчийн харилцааны газар, нэг хувийг Орон сууц нийтийн аж ахуйг удирдах газарт хүргүүлнэ. Мөн хурлын шийдвэрийг компанийн веб хуудсанд тавина.

Долоо. Хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурал, эчнээ санал хураалт

7.1. Шаардлагатай тохиолдолд ТУЗ ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.

7.2. Хяналтын зөвлөл, нийт гаргасан энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж байгаа этгээдийн шаардлага гаргасан бөгөөд хэлэцүүлэхээр санал болгож байгаа асуудал нь хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхийн асуудал бол ТУЗ ээлжит бус хурлыг энэ журамд заасны дагуу зарлан хуралдуулна.

7.3. Хууль болон компанийн дүрмээр тогтоосон хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хэлэцүүлэхээр хувь нийлүүлэгч, хяналтын зөвлөл ээлжит

бус хурлах санал гаргасан үед ТУЗ хурлыг заавал зарлан хуралдуулах үүрэгтэй бөгөөд хурлын зар мэдээг энэ журамд заасн дагуу хүргэнэ.

7.4. Хурлын бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг эчнээ санал хураалтаар шийдвэрлэж болно.

7.5. Эчнээ санал хураалтаар асуудал шийдвэрлэх тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

7.6. Эчнээ санал хураалтаар асуудал шийдвэрлэх үед эчнээ санал хураалтын зар мэдээг хурлын зар мэдээг хүргэхээр энэ журмаар тогтоосны дагуу хүргэх бөгөөд, саналын хуудсыг хувьцаа эзэмшигчийн мэйл хаягаа хүргэн, санал авах эцсийн хугацааг мэдээлсэн байна.

7.8. Эчнээ санал хураалтын дүнг ТУЗ-өөс томилсон тооллогын комисс гаргаж, ТУЗ уг комиссын тогтоолыг үндэслэн шийдвэр гаргана.



“Монголбаннер” ХК-ийн 2010 оны 4 дүгээр сарын 28-ний
өдрийн хувь нийлүүлэгчдийн хурлын
тогтоолын хавсралт.

“МОНГОЛБАННЕР” ХК-ИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс баримтлах ногдол ашгийн бодлого, иногдол ашиг хуваиралах нөхцөл журмыг “Компанийн тухай” хууль, Монголын компанийн засаглалын кодекст нийцүүлэн тодорхойлоход оршино.

1.2. Хувьцаа эзэмшигчид нь компанийн хувьцааг худалдан авч, хөрөнгө оруулалт хийхдээ тодорхой хэмжээний орлого олохоор төлөвлөдөг учраас өнөөгийн болон ирээдүйн хөрөнгө оруулагчид компанийн ашиг хуваарилалтын бодлого, ногдол ашигт хуваиралах ашгийн доод хязгаар, ашиг хуваиралах хэлбэр зэргийг тодорхой журамласан байх ёстой.

1.3. ТУЗ нь “Ногдол ашгийн бодлого”-ыг нийтийн хүртээл болгох үүрэгтэй. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга сонирхсон бүх этгээд уг баримттай танилцах боломж олгохоос гадна компанийн сайтад байрлуулсан байна.

Хоёр. Ногдол ашиг хуваиралах нөхцөл

2.1. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.

2.2. Компани дор дурьдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилна:

2.2.1. ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх

2.2.2. ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө компанийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгөөс багагүй байх

2.2.3. компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаагаа эргүүлэн авах нөхцөл байдал үүссэн эдгээр хувьцааг бүрэн эргүүлэн авсан байх

2.3. Компани дараах тохиолдолд заавал ногдол ашиг хуваарилна.

2.3.1. энэ бодлогын 2.2-т заасан нөхцөл хангагдсан

2.3.2. компани ашигтай ажилласан бөгөөд компанийн дүрэм болон хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрт заасан хөрөнгө оруулалтад зориулсан хуваарилалтыг бүрэн хийсний дараа хуваарилагдаагүй цэвэр ашиг үлдэж байгаа

Гурав. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр

- 3.1. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг ТУЗ гаргана.
- 3.2. Жилийн санхүүгийн тайланг аудитийн байгууллагаар хянуулан татварын байгууллагад өгснөөс хойш буюу жил бүрийн 3 дугаар сарын 10-ны дотор ногдол ашиг хуваарилах эсэх тухай асуудлыг ТУЗ-оөр хэлэлцэн шийдвэр гаргана.
- 3.3. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг нийтэд мэдээлж, хувийг Санхүүгийн зохицуулах хорооны мэдээллийн нэгдсэн санд хүргүүлнэ.
- 3.4. Нийтэд хүргэж байгаа мэдээлэлд ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх журмын талаар бүрэн тусгасан байх бөгөөд ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсэн бол түүний үндэслэлийг энэ журмын дагуу тайлбарласан байна.
- 3.5. Компани ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувь нийлүүлэгчдийн ээлжит хуралд тайлагнах бөгөөд тайлбартaa ногдол ашиг хуваарилах боломжгүй байдалд хүрсэн шалтгаан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тайлбар зэргийг тусгасан байна.

Дөрөв. Ногдол ашиг хуваарилах, тайлагнах

4.1. Ногдол ашиг төлөх хэлбэр, олгох хугацаа, журам нь хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна.

4.2. Ногдол ашиг хуваарлах тухай шийдвэрт ногдол ашиг олгож эхлэх хугацааг заасан байх бөгөөд энэ хугацаандаа ногдол ашгийг олгох ёстой. Ногдол ашгийг хугацаанд бүрэн олгоогүй зэргээр хувьцаа эзэмшигчдэд чирэгдэл учруулсан, хохироосон гүйцэтгэх удирдлагын ажилтанд хариуцлага хүлээлгэх журмыг “Ногдол ашгийн бодлого”-д тодорхой тусгасан байна.

Ногдол ашгийг олгох хэлбэр нь мөнгөн хөрөнгө, зах зээлд идэвхитэй арилжаалагддаг үнэт цаасны хэлбэртэй байх нь зохимжтой. Хувьцаа эзэмшигч дансны дугаараа албан ёсоор мэдэгдсэн нөхцөлд бэлэн бусаар шилжүүлж болно. Хувьцаа эзэмшигч өөрөө зөвшөөрсөн тохиолдолд эд хөрөнгийн хэлбэрээр олгож болно.



“МОНГОЛБАННЕР” ХК-ийн 2010 оны 4 дүгээр сарын 28-ний
өдрийн хувь нийлүүлэгчдийн хурлын
тогтоолын хавсралт.

“МОНГОЛБАННЕР” ХК-ИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл.

1.1. Энэхүү журмаар компаниас нийтэд хүргэх мэдээллийн жагсаалт, нийтэд хүргэх арга хэрэгслэл /нэвтрүүлэх, нийтлүүлэх мэдээллийн хэрэгслэл, давтамж/, хариуцах албан тушаалтан зэргийг тогтоосон байна. Нийтэд хүргэх мэдээллийг компанийн веб сайтад давхар тавьдаг байх ёстой.

1.2. Мэдээллийг цаг тухайд нь нээлттэй болгох замаар хувьцаа эзэмшигчид болон оролцогч талуудын итгэлийг нэмэгдүүлэх, дотоод буюу нийтэд хүрээгүй байгаа мэдээллийг шударга бусаар ашиглахаас сэргийлэх нь компанийн гүйцэтгэх удирдлагын үүрэг байна. Харин энэ үйл ажиллагаанд компанийн ТУЗ нь холбогдох гишүүнээр дамжуулан хяналт тавина.

1.3. Компанийн дэд захирал нь хууль, зохицуулах байгууллагаас тогтоосон журамд заасан болон бусад чухал ач холбогдол бүхий мэдээллийг цаг тухай бүр нийтэд хүргэхээр ТУЗ-ийн нарийн бичгийн даргад хүргүүлнэ.

1.4. Мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагаанд дараах зарчмыг удирдлага болгоно.

- тогтмол байх
- цаг хугацаандаа байх
- компанийн хувьцаа эзэмшигчид болон сонирхогч бусад этгээдэд бүгдэд нь тэгш хүртээмжтэй байх
- үнэн зөв байх
- агуулгын хувьд бүрэн байх
- компанийн бизнесийн эрх ашиг, нээлттэй байх зарчим хоёрын зохистой тэнцвэрийг хангах
- өөрийн үйл ажиллагааны доголдол, дутагдлыг нууж хаах, гоёчлон харуулах зорилго агуулаагүй

Хоёр. Нийтэд хүргэх мэдээлэл

- 2.25. Компанийн ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтнуудын тухай болон тэдгээр нь өөрчлөгдсөн тухай мэдээлэл;
- 2.26. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тухай мэдээлэл;
- 2.27. Нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой хувь хүн, хуулийн этгээдийн нэр /тэдгээр этгээд нь компанийн хувьцааг эзэмшиж байгаа бол/;
- 2.28. Нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд өөрчлөгдсөн тухай мэдээлэл;

- 2.29. Компанийн томоохон зээлдүүлэгчид, харилцагчдын тухай мэдээлэл /тухайн зээлдүүлэгчээс авсан зээлийн хэмжээ болон тухайн харилцагчаас хүлээн авсан бараа материал, тухайн харилцагчид нийлүүлсэн бараа бүтээгдэхүүн зэргийн дүн нь компанийн нийт борлуулалтын 10-аас дээш хувьтай тэнцүү бөгөөд тухайн харилцагчтай 2-оос дээш жил тогтмол хамтран ажиллаж байгаа бол томоохон зээлдүүлэгч харилцагч гэж үзнэ/;
- 2.30. Компанийн хараат, охин компанийн тухай мэдээлэл;
- 2.31. Компанийн халаасны хувьцааны тухай мэдээлэл;
- 2.32. Компанийн нэр, ерөнхий захиргааны оршин байх газар өөрчлөгдсөн тухай мэдээлэл;
- 2.33. Компанийн салбар, төлөөлөгчийн газрын тухай мэдээлэл;
- 2.34. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд гарсан өөрчлөлтийн тухай мэдээлэл;
- 2.35. Компанийн аудиторыг сонгон гэрээ байгуулсан, өөрчилсөн;
- 2.36. Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийн тухай;
- 2.37. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /дүрмийн сан/ -г нэмэгдүүлэх, хорогдуулах төслийг ТУЗ баталсан;
- 2.38. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг баталсан тухай;
- 2.39. Их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг ТУЗ юмуу хуульд заасан тохиолдолд хувь нийлүүлэгчдийн хурал баталсан тухай;
- 2.40. Компанийн үл хөдлөх хөрөнгийн 10-ээс дээш хувийг худалдсан, барьцаалсан, ямар нэг хэлбэрээр бусдад шилжүүлсэн тухай мэдээлэл;
- 2.41. Компанийн үйл ажиллагаа, хяналтын багц эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтнуудын үйлдэлтэй холбоотой асуудлаар хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэсэн, эсхүл тэдгээр этгээд гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож, хуулийн дагуу шийтгэгдсэн;
- 2.42. Төрийн болон орон нутгийн өмчлөлд байсан компанийн хувьцааны хяналтын багц хувьд шилжсэн;
- 2.43. Компанийг хуульд заасан хэлбэрээр өөрчлөн байгуулах төслийг ТУЗ баталсан;
- 2.44. Нийтэд санал болгон шинээр болон нэмж үнэт цаас гаргах төслийг ТУЗ, хувь нийлүүлэгчдийн хурлаар баталсан тухай мэдээлэл;
- 2.45. Компанийн санхүүгийн тайлан, төрийн зохицуулалтын байгуулагаас тогтоосон нэмэлт, тайлбар тодруулгын хамт;
- 2.46. Компанийн ул хөдлөх хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийлгэсэн тухай тайлан;
- 2.47. Компанийн борлуулалтын орлогын 10-аас дээш хувийг эзэлдэг үйл ажиллагаатай холбогдох аливаа тусгай зөвшөөрөл хүчингүй болсон, лицензийг худалдсан, барьцаалсан, аливаа хэлбэрээр бусдад шилжүүлсэн тухай;
- 2.48. Компанийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбогдон үүсч болох эрсдэлийн тухай мэдээлэл;

Гурав. Компанийн үйл ажиллагааны жилийн тайландаа заавал тусгагдах мэдээлэл

- 3.6. Компанийн зорилго, үйл ажиллагааны стратеги;
 - 3.7. Санхүүгийн байдал ба үйл ажиллагааны үр дүн;
 - 3.8. Хувьцаа эзэмшигчдийн статус болон хувьцаа эзэмшигчид эрх, үүргээ хэрхэн хэрэгжүүлсэн талаарх статистик тоо баримт;
 - 3.9. Хөрөнгийн нэмэгдсэн байдал ба санхүүгийн жилд гарсан капиталжих зардал;
 - 3.10. Бизнесийн орчин ба эрсдлийн хүчин зүйлүүд;
 - 3.11. Компанийн удирдлагад ажиллагсадын талаарх мэдээлэл;
 - 3.12. ТҮЗ-ийн дарга, гишүүд, аудиторууд болон гүйцэтгэх удирдлагуудын шагнал урамшуулал;
 - 3.13. Хараат бус аудиторууд, рейтингийн байгууллага болон бусад холбогдох байгууллагуудын үнэлгээний тайлан;
 - 3.14. Мэдээллийг нээлттэй болгох талаар хууль, зохицуулах байгууллагын журмын дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн эсэх, хэрэгжүүлээгүй бол хүлээсэн хариуцлага.
- 3.11. Ирэх онд Компанийн засаглалын тогтолцоо нь “Монголын компанийн засаглалын кодекс”-т заасан зарчмаас ялгаатай байгаа эсхүл уг зарчмыг хэрэгжүүлээгүй, дагаж мөрдөөгүй шалтгаан үндэслэл

3.11. Ирэх онд Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний төлөвлөгөө

Дөрөв. Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын өмнө хувьцаа эзэмшигчдэд заавал толилуулах мэдээлэл

- 4.10. Компанийн үйл ажиллагааны жилийн тайлан;
- 4.11. Жилийн санхүүгийн тайлан холбогдох тайлбар, тодруулга, аудитийн байгууллагын дүгнэлтийн хамт;
- 4.12. Ногдол ашиг хуваарилах тухай ТҮЗ-ийн шийдвэр, хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол үндэслэл;
- 4.13. Хянан шалгах зөвлөлийн тайлан;
- 4.14. Төлөөлөн удирдах болон хянан шалгах зөвлөлд нэр дэвшигчдийн тухай танилцуулга;
- 4.15. Хэрвээ ээлжит хурлаар компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудал хэлэлцэх бол нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, үндэслэл, тайлбарын хамт, компанийг өөрчлөн байгуулах асуудал хэлэлцэх бол өөрчлөн байгуулах хэлбэр, үндэслэл, өөрчлөн байгуулах журам, үүнтэй холбогдсон хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх журам зэргийг тусгасан өөрчлөн байгуулах төсөл, бусад холбогдох баримт бичиг;

- 4.16. Нэмж хувьцаа гаргах асуудал хэлэлцэх бол түүний борлуулалтаас олсон орлогыг хэрхэн зарцуулах тухай танилцуулга, эдийн засгийн үр ашгийн тооцоо, хувьцаа эзэмшигчид хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхээ хэрэгжүүлэх журам
- 4.17. Өрийн бичиг бусад үнэт цаас гаргах тухай асуудал хэлэлцэх бол бол түүний борлуулалтаас олсон орлогыг хэрхэн зарцуулах тухай танилцуулга, эдийн засгийн үр ашгийн тооцоо,
- 4.18. Хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бусад асуудлыг хэлэлцэхэд хувьцаа эзэмшигчдэд ямар бичиг баримт танилцуулахыг тухай бүр ТУЗ шийдвэрлэнэ.

Тав. Хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангах

- 5.1. Хууль, зохицуулах байгууллагын журам, компанийн дүрэм болон энхүү журмаар тогтоосон мэдээллийг нээлттэй болгохоос гадна хувьцаа эзэмшигчдийн хүссэн мэдээллийг цаг тухайд нь саадгүй гаргаж өгнө.
- 5.2. Компанийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг нэгдмэл сонирхолтой эзэмшиж байгаа этгээд нь компанийн нягтлан бодох бүртгэлийн болон гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэлтэй холбогдох мэдээллийг авах эрхтэй байна. Нэгдмэл сонирхолтой этгээд нь энэ тухайгаа Зохицуулах хороонд мэдэгдсэн тодорхойлолт авсан байна.
- 5.3. Хувьцаа эзэмшигчдийн хүсэлтээр компанийн мэдээллийг гаргаж өгөх нь ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг байна.
- 5.4. Мэдээлэл хүсэж байгаа хувьцаа эзэмшигч хүсэлтдээ өөрийн болон эцэг /эх/-ийн нэр, хаяг /шуудангийн болон электрон/, холбоо барих утас, эзэмшиж байгаа хувьцааны тоо, төрөл, авахыг хүсэж байгаа мэдээлэл, мэдээлэл авах хэлбэр /биечлэн, бичгээр, электрон шуудангаар/ зэргийг заасан байна.
- 5.5. Уг хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор /мэдээлэл ач холбогдоо алдахаар бол боломжит богино хугацаанд/ ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцан мэдээллийг боломжит хэлбэрээр хүргүүлнэ.
- 5.6. Хувьцаа эзэмшигчийн хүссэн мэдээлэл нь хууль тогтоомж болон компанийн дотоод бичиг баримтаар тогтоосон нээлттэй болгох мэдээллийн жагсаалтад багтаагүй бөгөөд компанийн бизнесийн нууцад хамаарахаар мэдээлэл бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг хүргүүлнэ.



**“Монголбаннер” ХК-ийн 2010 оны 4 дүгээр сарын 28-ний
өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын
тогтоолын хавсралт....**

“Монголбаннер” ХК-ийн дотоод хяналтын журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмаар компанийн дотоод хяналтын албаны чиг үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хэрэгжүүлэх, тайлагнах, хяналтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг зохицуулна.
- 1.2 Компанийн дотоод хяналтын үйл ажиллагааг дотоод хяналтын алба хэрэгжүүлэх бөгөөд уг алба нь газар тариалангийн үйлдвэрлэл, санхүү эдийн засаг, бизнес, эрх зүйн чиглэлийн аль нэгээр нь мэргэшсэн дээд боловсролтой, ял шийтгэл эдлэж байгаагүй 1 хүн байна.
- 1.3 Дотоод хяналтын алжилтан ь Монгол Улсын хууль, Компанийн дүрэм, ТУЗ-өөс баталсан компанийн засаглалын болон бусад дотоод журмууд, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржээс гаргасан журам заавар, ТУЗ болон Ерөнхий захирлын албан даалгavar, шаардлагын хэрэгжилт, компанийн үйл ажиллагааны стандартын хэрэгжилт, хөрөнгийн зарцуулалт, төсөв, төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллана.
- 1.4 Энэхүү журамд компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар нэмэлт өөрчлөлт оруулж, батална.
- 1.5 Журмын хэрэгжилтэнд компанийн гүйцэтгэх захирал өдөр тутам хяналт тавина.
- 1.6 Компанийн ажилтнууд дотоод хяналтын ажилтны шаардсан мэдээллийг хугацаанд нь бүрэн гаргаж өгөх үүрэгтэй.
- 1.7 Харилцагчид, хэрэглэгчдээс ирсэн өргөдөл гомдлыг хэрхэн хүлээн авч, шийдвэрлэж байгаа байдлыг 7 хоног бүр хянаж, шуурхай зөвлөгөөн дээр үр дүнг танилцуулж байна.
- 1.8 Хяналтын алба нь Компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтэд байнга анхаарал тавьж, нийт ажилтан албан хаагчдын ажил үүргийн биелэлтийг хангах зорилго тавьж ажиллана.

ХОЁР. Дотоод хяналтын албаны чиг үүрэг

- 2.1. Дотоод хяналтын ажилтнуудыг ТУЗ томилох ба тухайн жилд хийгдэх хяналт шалгалтын хуваарийг батлана.
- 2.2 Дотоод хяналтын алба нь хяналт, шалгалтын тайланг ТУЗ-д жилд 2-оос доошгүй удаа танилцуулна.
- 2.3 Дотоод хяналтын алба нь компаний ажилтнуудаас хяналт шалгалтад шаардлагатай бүхий л мэдээллийг гаргуулан авах эрхтэй.
- 2.4 Дотоод хяналтын алба нь:
 - 2.4.1 компанийн үндсэн үйл ажиллагааны стандартын хэрэгжилтэд хяналт тавих.

- 2.4.2 компанийн санхүү, төсөв, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих.
- 2.4.3 компанийн үйл ажиллагаанд хууль тогтоомж, бусад холбогдох журмууд хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавих.
- 2.4.4 Компанийн засаглалын дотоод журмуудын хэрэгжилтэд хяналт тавих.
- 2.4.5 харилцагч, хэрэглэгчдийн гомдлыг хэрхэн шийдвэрлэж байгаад хяналт тавих.
- 2.4.6 Компаний бичиг баримтын хадгалалт зэрэгт хяналт тавьж ажиллана.

Гурав. Дотоод хяналтын алба нь дараах эрх үүрэгтэй байна.

- 3.1. Энэ журмын 2 дугаар зүйлд заасан чиглэл, удирдамжийн дагуу шалгалт явуулах
- 3.1.1. хууль тогтоомжийг чанд мөрдөж, хөндлөнгийн нөлөөнд үл автах, шударга ёсыг баримталж, байгууллага албан тушаалтны нэр төрийг хүндэтгэх
- 3.1.2. шалгалт явуулсан тухай танилцуулга, акт бусад баримт бичгийг зохих журмын дагуу үйлдэж гарын үсгээр баталгаажуулах,
- 3.1.3. шалгалтын акт, материалыг зохих этгээдэд танилцуулж, гарын үсэг зуруулах, хэрэв зөвшөөрөөгүй буюу гарын үсэг зурахаас татгалзвал энэ тухай тайлбарыг бичгээр авах,
- 3.1.4. Хийсэн шалгалтын дүгнэлт, танилцуулга, акт дахь нотлох баримтын үндэслэл, ашигласан мэдээллийн үнэн зөвийг хариуцах,
- 3.1.5. шалгалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах,
- 3.1.6. шалгалтай холбогдолтой мэдээллийн нууцыг чанд хадгалах,
- 3.1.7. шалгалтад зайлшгүй шаардлагатай баримт материал, мэдээллийг компанийн холбогдох ажилтнаас гаргуулах,
- 3.1.8. шалгуулж буй этгээд түүний нэр төрийг гутаах, айлан сүрдүүлэх үйлдэл гаргавал зохих байгууллагад гомдол гаргах,
- 3.1.9. шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, арилгах, төлбөр барагдуулах талаар хугацаатай үүрэг өгөх, акт тавих, биелэлтийг хангуулах, хариу авах
- 3.1.10. Ноцтой зөрчил гаргасан ажилтанд ногдуулах хариуцлага, авах арга хэмжээг төлөвлөж удирдлагад танилцуулах, шийдвэрлүүлэх,
- 3.1.11. шаардлагатай тохиолдолд зөрчил гаргасан ажилтныг халах тухай саналыг холбогдох байгууллагад гаргах,

Дөрөв. Хүлээх хариуцлага

- 4.1 Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль, тогтоомж болон ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу дараах хариуцлага хүлээлгэнэ.
 - 4.1.1. Сануулах
 - 4.1.2. Цалингийн хэмжээг тодорхой хугацаагаар, тодорхой хувиар бууруулах
 - 4.1.3. Ажилтныг ажлаас халах
- 4.2 Ажилтанд сахилгын болон захиргаа, эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн эсэхээс үл хамааран учруулсан хохирлыг компанийд төлүүлэн авна.
- 4.2 Хэрэв ажилтны гаргасан зөрчил нь ноцтойд тооцогдож байвал эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.



“Монголбаннер” ХК-ийн 2010 оны 4 дүгээр сарын 28-ний
өдрийн хувь нийлүүлэгчдийн хурлын тогтоолын хавсралт.

“МОНГОЛБАННЕР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн /цаашид ТУЗ/ гишүүдэд тавих шаардлага, ТУЗ-ийн гишүүнээр сонгуулахаар нэр дэвшүүлэх, шалгаруулах журам, гишүүдийн үүрэг хариуцлага, гишүүдийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх журам, даргын бүрэн эрх, ТУЗ-ийн хороодын чиг үүрэг, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг зэргийг тогтооход оршино.

Хоёр. ТУЗ-ийн гишүүдэд тавих шаардлага

- 2.1. Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байна.
- 2.2. Компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч нь дараах шаардлагыг хангасан байна.
 - 2.2.1. Дээд боловсролтой
 - 2.2.2. Компанийн үйл ажиллагаа явуулж байгаа аль нэг салбарын чиглэлээр эсхүл, санхүү эдийн засаг, хууль зүй, удирдахуйн ухааны чиглэлээр мэргэшсэн /энэ чиглэлээр магистраас доошгүй зэрэгтэй эсхүл тухайн чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай/
 - 2.2.3. Ял шийтгэгдэж байгаагүй
 - 2.2.4. Өмнө нь дампуурсан компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаагүй
- 2.3. Компанийн ТУЗ нь 3-аас доошгүй хараат бус гишүүнтэй байна.
- 2.4. Хараат бус гишүүнд нэр дэвшигч нь энэ зүйлийн 2.2-т зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна.
 - 2.4.1. Компанийн хяналтын багц хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн бусад гишүүн, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны төрсөн болон үрчилсэн эцэг, эх, ах, дүү, мөн түүнчлэн эхнэр нөхөр, үр хүүхэд, ач зээ болон тэдгээрийн эхнэр нөхөр, ах дүү биш өөрөөр хэлбэл садан төрлийн ямар нэг холбоогүй
 - 2.4.2. компани болон толгой, охин, хараат компанийд сүүлийн 3 жил ажиллаж байгаагүй, одоо ажилладаггүй,
 - 2.4.3. компанийн томоохон харилцагчийн хяналтын багц эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан биш /нэг жилд тухайн харилцагчтай хийсэн хэлцлийн нийт дүн нь компанийн нийт активийн 10-аас дээш хувьтай тэнцэж байвал томоохон харилцагч гэж үзнэ/
 - 2.4.4. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн нэгээс доошгүй нь мэргэшсэн нягтлан бодогч байвал зохино. Мэргэшсэн нягтлан бодогч биш тохиолдолд нягтлан бодох бүртгэл аудитийн чиглэлээр магистраас доошгүй зэрэгтэй, мөн чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай этгээд байна.
- 2.5. Гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтан ТУЗ-ийн гишүүдийн 1/3 – эс олонгүй байна.

2.6. ТУЗ-ийн дарга нь гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтан байхыг хориглоно.

Гурав. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг жагсаалтад бүртгэх журам

3.1. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэх, энэхүү журмаар тогтоосон шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянах, нэр дэвшигчийг жагсаалтад бүртгэх эсэхийг шийдвэрлэх асуудлыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос сонгогдсон З гишүүн бүхий Нэр дэвшүүлэх хороо хариуцан хэрэгжүүлнэ. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга байна.

3.2. Компанийн нийт гаргасан хувьцааны 10-аас доошгүй хувийг нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.

3.3. Энэ зүйлийн 3.2-т зааснаас бусад хувьцаа эзэмшигчид ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.

3.4. Хувьцаа эзэмшигч нь ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх саналаа ТУЗ-ийн нэр дэвшүүлэх Хороонд ирүүлнэ. Саналдаа ердийн гишүүн, хараат бус гишүүний алинд дэвшүүлж байгаа болох, энэ журмын 2-т заасан шаардлагыг нэр дэвшигч хэрхэн хангаж байгаа тухай мэдээлэл болон уг мэдээллийг нотлох баримтын хамт ирүүлнэ. Саналд энэ журмын 1-р хавсралтаар баталсан “Нэр дэвшигчийн зөвшөөрөл”, 2-р хавсралтаар баталсан “Нэр дэвшигчийн анкет” зэргийг хавсрагасан байна.

3.5. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэхээр хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн санал, хавсрагасан баримтуудыг ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны нарийн бичгийн дарга /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн хороодын нарийн бичгийн даргыг хавсран эрхэлнэ/ хүлээн авч, бүрдлийг шалгаад бүрэн бүрдсэн бол хүлээн авсны дараах ажлын өдөр Хорооны даргад танилцуулна. Хорооны дарга ирүүлсэн бичиг баримтад үндэслэн тухайн хүнийг нэр дэвшигчдийн жагсаалтад бүртгэх эсэх тухай санал үндэслэлээ Хорооны хуралд ажлын З хоногийн дотор танилцуулна. Хорооны гишүүдийн олонхийн саналаар нэр дэвшигчийг жагсаалтад бүртгэнэ. Тухайн нэр дэвшигчийг жагсаалтад бүртгэхээс татгалзсан тохиололд үндэслэлээ нэр дэвшүүлсэн хувьцаа эзэмшигчид бичгээр мэдэгдэнэ. Хувьцаа эзэмшигч нэр дэвшсэн этгээдийг жагсаалтад бүртгэхээс татгалзсан нь үндэслэлгүй гэж үзвэл бичгээр мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын З хоногийн дотор ТУЗ-д гомдол гаргах эрхтэй. ТУЗ хувьцаа эзэмшигчийн гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан асуудлыг авч хэлэлцээд шийдвэр гаргана. ТУЗ-ийн шийдвэр эцсийн шийдвэр байна.

3.6. Нэр дэвшигчийг жагсаалтад бүртгэхээс дараах үндэслэлээр татгалзаж болно.

3.6.1. Нэр дэвшигч нь энэ журмын 2 дугаар хэсэгт заасан шаардлагыг хангаагүй

3.6.2. Нэр дэвшигч нь өмнө нь компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байхдаа “хангалтгүй ажилласан” гэсэн дүгнэлт авсан

3.7. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдийн нэрийг хувь нийлүүлэгчдийн хурлын санал авах хуудсанд оруулах бөгөөд энэ журмын 2-р хавсралтаар баталсан товч түүхийг хувь нийлүүлэгчдийн хуралд зориулсан мэдээлэлд оруулсан байна.

Дөрөв. ТУЗ-ийн гишүүдийн үүрэг хариуцлага

4.1. ТУЗ-ийн гишүүнд нэрийг нь /өөрөө нэрээ дэвшүүлж болно/ дэвшүүлж байгаа этгээд нь энэхүү журам, компанийн дүрмийг сайтар судалсан байх бөгөөд ТУЗ-ийн гишүүний хувьд үүргээ бүрэн биелүүлэх цаг, боломжтой эсэхээ сайтар тунгаан зөвшөөрөл олгоно.

4.2. ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсон тохиолдолд өөрийн үүргээ хариуцлагатай биелүүлэхийн тулд энэхүү журам, “Компанийн дүрэм”-ээр тогтоосон үүргийг хэрэгжүүлэх талаар зохих хүчин чармайлт гаргаж ажиллана.

4.3. ТУЗ-ийн болон ТУЗ-ийн хороодын хуралдаанд биеэр юмуу хэлэлцэх асуудал бүрт тодорхой санал тайлбартай бичгээр саналаа өгөх замаар оролцоно. Гадаадад болон орон нутагт ажиллаж, амарч эзгүй байгаа тохиолдолд ч хурлын материалыг е-мэйлээр хүлээн авч хариу өгөх юмуу хуралдааны явцад утсаар саналаа өгөх, санал солилцох замаар оролцох ёстой. Гэхдээ боломжтой тохиолдолд биеэр оролцоход анхаарна. Учир нь хурлаар урьдчилан товлоогүй чухал асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх шаардлага олонтоо тулгарна.

4.4. ТУЗ-ийн гишүүн нь заавал өөрийн е-мэйл хаягтай байх бөгөөд мэдээллийг хаягаараа тогтмол хүлээн авч, хариу өгдөг байна.

4.5 ТУЗ-ийн болон Хороодын нийт хуралдааны 40-өөс дээш хувьд нь аль нэг хэлбэрээр оролцож чадаагүй бол уг гишүүнийг ТУЗ-д дахин нэр дэвшүүлэхийг хориглоно.

4.6 ТУЗ-өөс гаргаж буй шийдвэр мэдээлэл дээр үндэслэсэн, бодитой, компанийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийн тэнцвэрийг хангасан байхын тулд ТУЗ-ийн гишүүдэд шийдвэр гаргах үндэслэл болсон мэдээллийг бүрэн хүргүүлсэн байх бөгөөд гишүүд эдгээр мэдээллийг сайтар судалсан байх ёстой.

4.7. ТУЗ-ийн гишүүдэд мэдээлэл хүргэх асуудлыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцах бөгөөд гүйцэтгэх захирал хяналт тавина. ТУЗ-ийн гишүүд мэдээлэл аваагүй, дутуу юмуу хугацаа хожимдож авсан асуудлаар ТУЗ-ийн даргад гомдол гаргах бөгөөд ТУЗ-ийн дарга буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх, ач холбогдоо алдаагүй мэдээллийг нөхөн хүргүүлэх арга хэмжээ авна.

4.8. ТУЗ-ийн гишүүдийн мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх талаар ТУЗ-ийн дарга холбогдох арга хэмжээ авна. Үүний тулд уг арга хэмжээний зардлын төсвийг ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд оруулан батлуулах бөгөөд ТУЗ-ийн гишүүдийг хурал зөвлөгөөн, семинар оролцуулах, мэргэжлийн сэтгүүл, бусад мэдээлэл олж хүргүүлэх зэрэг арга хэмжээнд зарцуулна.

4.9. Тухайн гишүүнийг оролцуулахаар ТУЗ-өөс урилга хүргүүлсэн сургалт, семинар, хурал, зөвлөлгөөнд заавал оролцоно. Эдгээр арга хэмжээний 60-аас доош хувьд нь оролцсон бол ТУЗ-ийн гишүүнд дахин нэр дэвшүүлэхийг хориглоно.

Тав. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн үүрэг хариуцлага

5.1. ТУЗ-ийн хараат бус гишүүд нь ТУЗ-ийн гаргаж буй шийдвэр ялангуяа их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай шийдвэр нь хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхолын тэнцвэр, хувьцаа эзэмшигчид болон компанийн ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж байгаа эсэх, хувьцаа эзэмшигчид ялангуяа, хяналтын бус хувьцаа эзэмшигчдийг мэдээлэлээр хангах үүргээ гүйцэтгэх удирдлага хэрхэн хэрэгжүүлж байгаа, дотоод хяналт зохих шаардлагын түвшинд ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих явдал юм.

5.2. Хараат бус гишүүдийн нэг нь ТУЗ-ийн аудитийн хороог даргална. Энэ гишүүн нь нягтлан бодох бүртгэл, аудитийн чиглэлээр мэргэшсэн байна.

5.3. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай ТУЗ-ийн шийдвэрийг ТУЗ-ийн хараат бус гишүүдийн бүгдийнх нь зөвшөөрөлтэй гаргана.

5.4. Хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хэрхэн хангаж байгаа байдалд хяналт тавих үүргийг хараат бус гишүүдийн аль нэгэнд хариуцуулна. “Мэдээллийн үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийн талаар улирал бүр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гаргаж, гүйцэтгэх захирал хянасан тайланг уг гишүүн нь хүлээн авч хянана. Мөн Нийслэлийн өмчийн газар, Орон сууц нийтийн аж ахуйг удирдах газарт эдгээр байгууллагын журмын дагуу гаргаж хүргүүлэх мэдээллийн талаарх үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаа тухай мэдээллийг жилд 2-оос доошгүй удаа биечлэн авч хяналт тавина.

Зургаа. ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх

6.1. ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаанд Нэр дэвшигчдээх хороо дүгнэлт өгнө.

6.2. Нэр дэвшигчдээх Хороо нь ТУЗ-ийн гишүүдийн хурал, зөвлөгөөн, семинарт оролцсон байдал, ТУЗ-ийн хорооны гишүүний хувьд ТУЗ-ийн болон Хорооны хуралд хэрхэн оролцсон, ТУЗ-өөс болон холбогдох хорооноос өгсөн үүрэг даалгаварыг хэрхэн биелүүлсэн зэрэг үзүүлэлтийг харгалzan дүгнэлт өгнө.

6.3. ТУЗ-ийн гишүүн бүрээр ТУЗ-ийн нарийн бичгийн даргын гаргаж өгсөн бүртгэл, Хороодын дарга нарын гаргасан тодорхойлолтыг үндэслэн гаргасан дүгнэлтийг ТУЗ-ийн жил бүрийн 2-р сарын хуралд танилцуулж байна.

6.4. ТУЗ-ийн гишүүнд “хангалтгүй ажилласан” гэсэн дүгнэлт өгсөн бол үндэслэлээ бичгээр тайлбарласан байх бөгөөд тухайн гишүүний тайлбарыг авсан байна.

Долоо. ТУЗ-ийн хороодын чиг үүрэг

Нэр дэвшигчдээх хорооны чиг үүрэг

7.1 Компанийн ТУЗ-ийн гишүүнд тавих ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага зэрэг шалгуурыг тогтоох, нэр дэвшигчдээд тавих шаардлагыг тодорхойлох

7.2 ТУЗ-ийн гишүүд болон нэр дэвшигчдийн ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлагад үнэлэлт, дүгнэлт өгөх

7.3 Нэр дэвшигчдийг бүртгэх, сонгон шалгаруулах, бүртгэхээс татгалзсан бол мэдэгдэх, гомдлыг хүлээн авах, хянах үйл ажиллагааны горим

7.4 ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх журам тогтоох, үнэлэлт дүгнэлт өгөх,

7.5 Гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтанд тавих шаардлагыг тогтоох, тэднийг сонгон шалгаруулах, тэдэнтэй байгуулах гэрээний нөхцлийг, түүний дотор цалин, шагнал урамшууллыг тогтоох

7.6 Гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх захирлаас өгсөн үнэлгээтэй танилцаж дүгнэлт гаргах

Найм.Шагнал урамшууллын хорооны чиг үүрэг

8.1 Компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны шагнал урамшууллын бодлогыг тодорхойлох санал боловсруулах, үе үе хянаж үзэх.

8.2 ТУЗ-ийн гишүүдийн шагнал урамшуулал нь баталсан журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих

8.3 Компанид мөрдөж буй ажлын үр дүнтэй холбосон аливаа урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх

8.4 Ажиллагсдын тэтгэвэрийн даатгалын аливаа хөтөлбөрийг судалж, сонголт хийх

Ес.Аудитийн хорооны чиг үүрэг

9.1 Компанийн санхүүгийн тайлангийн үнэн бодит байдлыг хангах нь энэ хорооны үндсэн чиг үүрэг болно. Энэ чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд гүйцэтгэх удирдлагаас толилуулж байгаа санхүүгийн мэдээллийг бодит байдлыг хангах, НББ-ийн зарчим, болон холбогдох хууль журамд нийцүүлэх, дүн шинжилгээ хийхэд маш чухал үүрэг гүйцэтгэх ёстой.

9.2 Санхүүгийн мэдээллийн болон нягтлан бодох бүртгэлийн асуудлаар хөндлөнгийн аудитийн болон дотоод хяналтын албатай байнга санал солилицдог байна.

9.3 Дотоод хяналтын албаны ажилтнуудын мэдлэг боловсрол, мэргэшил, дадлага туршлага, хараат бус байдалд тавих шаардлагыг тодорхойлж, тэдний ажлын үр дүнг үнэлэх ёстой.

9.4 Дотоод хяналтад тулгарч буй асуудлыг шийдвэрлэх чадвартай байх ёстой. Зохистой дотоод хяналтын тогтолцоо бүрдүүлэх үүрэгтэй

9.5 Дотоод хяналтын тогтолцоо болон эрсдэлийн удирдлага үр дүнтэй байгаа эсэхэд хяналт тавьж дүгнэлт өгнө.

9.6 Өөрийн чиг үүргийн хэрэгжилтийн талаар ТУЗ-д тогтмол мэдээлж, хөндлөнгийн аудиторыг сонгох болон тэдний гэрээт ажилын хөлсний хэмжээг тогтоох талаар санал гаргана.

9.7 Сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавина.

9.8 Аудитийн хороо чиг үүргээ зохих ёсоор биелүүлэхийн тулд гишүүдийн дийлэнх олонх нь хараат бус гишүүд байх нь зохистой. Хорооны дарга нь хараат бус гишүүн байх бөгөөд НББ аудитийн чиглэлээр мэргэшсэн байна.

Арав. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэг, хариуцлага

10.1 ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ батална. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь бичиг хэргийн болон комьютерийн сайн мэдлэгтэй, хариуцлагатай, гадаад хэлний зохих мэдлэгтэй хүн байна.

10.2 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн бүх бичиг хэргийг хариуцан хөтлөх үүрэгтэй.

10.3 ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг бүрэн хариуцах бөгөөд хурлын зар, хэлэлцэх асуудалтай хобоотой мэдээлэл, гарах шийдвэрийн төслийг гишүүдийн мэйл хаягаар хурал хуралдахаас ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлсэн байна.

10.4 ТУЗ-ийн болон хороодын хурлын ирцийг бүртгэн тухай бүр хурал даргалагчаар гарын үсэг зуруулж байна.

10.5 ТУЗ-ийн гишүүдэд мэдээлэл хүргэх, хурал, семинарын урилга хүргэх зэрэг асуудлыг биечлэн хариуцна.

10.6 ТУЗ-ийн гишүүд хүндэтгэх шалтгааны улмаас урилга ирүүлсэн хурал, семинарт оролцож чадахгүй бол энэ тухайгаа ТУЗ-ийн нарийн бичгийн даргад заавал мэдэгдэнэ.

10.7 ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эзгүйд түүний үүргийг орлох этгээдийг ТУЗ-ийн дарга томилно.

Арван иэг. ТУЗ-ийн даргын бүрэн эрх

11.1 ТУЗ-ийн дарга нь дараах бүрэн эрхтэй.

- ТУЗ-ийн дарга нь гишүүдээр хэлэлцүүлэн баталсан ТУЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд зайлшгүй шаардлагатай нэмэлт оруулах,

- ТУЗ-ийн хороодын даргыг томилох
- ТУЗ-ийн гишүүдийн ажлын үр дүнг хэлэлцэн батлахад шийдвэрлэх санал гаргах, өөрөөр хэлбэл гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд ТУЗ-ийн даргын саналаар шийдвэрлэнэ.
- Гишүүдэд компанийн үйл ажиллагааны үр дүнгээр шагнал урамшуулал олгох санал гаргах
- ТУЗ-ийн хурлыг удирдах,
- гишүүдийг гадаад, дотоодын хуралд семинарт оролцуулах асуудлыг шийдвэрлэх
- ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн, төлөвлөгөөний биелэлтийг хариуцна.

Арван хоёр. ТУЗ-ийн чиг үүрэг

12.1 ТУЗ нь компанийг зүй зохистой удирдах үүднээс дараах үүргийг гүйцэтгэж, компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавина.

- Компанийн үйл ажиллагааны чиглэл, зорилго, стратегийг тодорхойлох;
- Бизнес төлөвлөгөө болон жилийн төсвийг батлах;
- Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх, удирдлагын үр ашигтай байдалд мониторинг хийх;
- Гүйцэтгэх захирлыг сонгон гэрээ байгуулах, өөрчлөх, цалин, шагнал урамшууллын хэмжээг тогтоох;
- Эрсдлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцоог зөв зохион байгуулах, санхүүгийн үйл ажиллагаа, үндсэн үйл ажиллагааны зардалд мониторинг хийх;
- Компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг хангах, нягтлан бодох бүртгэл, аудитийн олон улсын стандартыг нэвтрүүлэх ажиллагааг удирдан зохион байгуулах;
- Компани мэдээллээ нээлттэй болгох үйл ажиллагаанд хяналт тавих
- Компанийн удирдлагууд болон хувьцаа эзэмшигчдийн хооронд сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд тэдний хооронд зуучлагчийн үүрэг гүйцэтгэн, зөв зохицуулах;
- Хяналтын багц эзэмшигчид гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хэт нөлөөлөхгүй, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд мониторинг хийх замаар хувьцаа эзэмшигчид, бусад оролцогч талуудын эрх ашгийг хамгаалахаас гадна компани төлбөрийн чадваргүй болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

“Монгол баннер”(Монгол шинэс)ХК-ийн 2009 оны
дөрөвдүгээр улирлын санхүүгийн тайлан

/төгрөгөөр /

| Балансын зүйл | Үлдэгдэл | | Балансын зүйл | Үлдэгдэл | |
|-----------------------------------|-------------|--------------|--|---------------|---------------|
| | I сарын 1 | XII сарын 31 | | I сарын 1 | XII сарын 31 |
| Хөрөнгө | | | Өр төлбөр | | |
| Эргэлтийн хөрөнгө | | | Дансын өглөг | 373490.00 | |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 60647.48 | 123743911.48 | Бусад татварын өглөг | 1421975.00 | |
| Дансны авлага | 4541000.00 | 4541000.00 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 1795465.00 | |
| Бараа материал | 3768219.00 | | Өр төлбөрийн нийт дүн | 1795495.00 | |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 8369866.48 | 128284911.48 | Хувьцаат капиталын дүн | 54533452.25 | 54533452.25 |
| Машин тоног төхөөрөмж | 32614095 | | Дахин үнэлгээний нөөц | | 92086160.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (23320345) | | Хуримтлагдсан ашиг /алдагдал/ | (16334700.47) | (18334700.77) |
| Тавилга эд хогшил | 25299745 | | Өмнөх үеийн | (16334700.47) | (18334700.77) |
| Хуримтлагдсан элэгдэл | (2969145) | | Эзэмшигчдийн өмчийн дүн | 38198751.48 | 128284911.48 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 31624350.00 | | | | |
| Нийт хөрөнгийн дүн | 39994216.43 | 128284911.48 | Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн | 39994216.43 | 128284911.48 |

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2010 оны дөрөвдүгээр сарын 01

Тендер шадгаруулалтын нэр:

Сэлэнгэ аймагт архивын зориулалттай
нягруулсан төмөр шүүгээ нийлүүлэх ажлын тухай битүүмжилсэн тендert эрх бүхий оролцогчыг урьж
байна.

Тендерийн баримт бичгийг /хүсвэл нэмэлт хувийг/ бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь **50 000** төгрөгөөр худалдан авч болно.

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн хоёр хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийг **2010 оны тавдугаар сарын 03-ны өдрийн 15.00** цагаас өмнө доорхи хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендert оролцогчдыг байлцуулан тендерийг **2010 оны тавдугаар сарын 03-ны өдрийн 15.30** цагт нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.


Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар
Хөгжлийн бодлогын хэлтэс
1-р давхар 107 тоот өрөө

TIME OUT

8

2010 ОНЫ ГУРАВДУГААР САРЫН 15. ДАВАА № 48 /1350/

ДОЛОО ХОНГОЙН ГЭРЭЛ ЗУРАГ



Однын дунд болороор чимсэн микрофон моодонд орж байна. "Spice Girls" хамтлаг, Kylie Minogue болон "Same Difference" зэрэг олон хамтлаг, дуучид тайлан дээр "Couture Crystal Bling Mic" брэндийн болор микрофоноо барин тайлан дээр гарч үрэхэд нуд гялбам гялалзаж, яахын аргагүй хараа булаадаг аж. Дэлхийн одуудтай энэ зэрэгцэн Монголын поп хатагтай, зүүны манлай дуучин Б.Сарантуяа ч Swarovski-ийн болороор чимэглэгсэн микрофонтой болсон. Дуучин бүсгүйд найзууд нь олон улсын эмэгтэйчүүдийн баярын бэлэг болгож тус микрофоныг бэлэглэсэн юм. Тус брэндийн микорфоны шигтгээ бурийг нарийн гар урлалын аргаар хийсэн бөгөөд 1500 ширхэг Swarovski-ийн жижиг болороор чимэглэжээ. Энэ тансаг микрофоны үнэ 395.00 паунд буюу ёсөн зуу гаруй мяанган төгрөг аж.

16-21°C

ОТРЫН НУТАГ ХЭРДЭН БАЯН-УЛААН ОРЧМООР: Үүлшинэ Шөнөдөв цас орохгүй. Өдөртөө цас орно. Салхи баруун хойноос секундэд 7-12 метр. Шөнөдөв 26-28 градус, өдөртөө 23-25 градус хүйтэн байна.

| Тайлбар |
|-----------|
| Цэлмэг |
| Үүлээрхэг |
| Бүрхэг |
| Цастай |
| Шуурна |

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Монголбаннер" ХК-ний хувь нийлүүлэгчдийн эзлжит хурлыг 2010 оны 04 сарын 28 ний өдрийн 18 цагт, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Жамъянгүний гудамж-12, Гранд Оффис Төвийн 8.2 тоот хурлын танхимд хийхээр болсон тул нийт хувьцаа эзэмшигч та бүхнийг хувь нийлүүлэгчдийг хуралдаа идэвхитэй оролцохыг урьж байна.

Бүртгэх өдөр: 2010 оны 03 сарын 16

Хэлэлцэх асуудал:

- Компанийн 2009 оны санхүүгийн тайлан,
- 2010 оны ажлын төлөвлөгөө, үйл ажиллагааг өргөжүүлэх талаарх асуудал,
- Компанийн нэрэнд өөрчлөлт оруулах асуудал
- Хянан шалгах зөвлөлийн тайлан,
- Бусад.

Залруулга:

Сонини өмнөх дугаарт хурлын бүртгэлийн өдрийг 2010 оны 03 сарын 18 хэмээн зарласан ч тодорхой шалтгааны улмаас хоёр өдрөө урагшилж, бүртгэл 2010 оны 03 сарын 16 болсныг анхаарна уу.


Холбоо барих утас:

99022672, 99096318

Хурал зохион байгуулах комисс

Исландын галт
уулын дэлбэрэлт
дэлхий дахинд
нөлөөлж магадгүй


Хэдэн өдрийн турш үргэлжилж буй Исландын галт уулын дэлбэрэлт дэлхийн хэмжээнд нөлөөлж гадгүй гэж зарим эрдэмтэн анхаруулж байна. Өнгөрсөн үеийн түүхийг сөхөж харьцуулбал энэ галт уулыг даган ойролцоо Катла хэмээх галт уул дэлбэрэх бөгөөд таамглаж буйгаар Катла галт уул дэлбэрвэл мөсөн оргил нь хайлж, гамшигт үерийн аюул дагуулах юм байна. Хэдийгээр дэлбэрсэн галт уул хэн нэгэнд аюул учруулаагүй бай-



Чехийн Прага хотод АНУ, ОХУ цөмийн зэвсэг бууруу шинэ гэрээнд гарын үсэг зурн

Бэлтгэсэн Б.НАРАНТУЯА

АНУ, ОХУ цөмийн зэвсгийн тоогoo бууруулах шинэ гэрээндээ гарын үсэг зурах үйл ажиллагааг Прагад зохион байгуулахыг зөвшөөрсөн тухай Чехийн Гадаад хэргийн яамнаас мэдээллээ. Энэ мэдэгдэл нь АНУ болон ОХУ-ын хоорондын цөмийн зэвсэг бууруулах шинэ гэрээ амжилттай болж, төгсгөлийн шатанлаа одж буйг ипөрхийж байна гэж



"Монгол Шинэс" (Монголбаннер) ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

"Монгол Шинэс" (Монголбаннер) ХК-ийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлыг 2010 оны дөрөвдүгээр сарын 28-ны өдрийн 18.00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Жамъян гүний гудамж-12, "Гранд оффис" төвийн 82 тоот хурлын танхимд хийхээр бол тулнийт хувьцаа эзэмшигч та бүхнийг хувь нийлүүлэгчдийг хуралдаа идэвхитэй оролцохыг урьж байна.

Бүртгэх өдөр:

2010 оны гуравдугаар сарын 16

Хэлэлцэх асуудал:

- Компанийн 2009 оны санхүүгийн тайлан,
- 2010 оны ажлын төлөвлөгөө, үйл ажиллагааг өргөжүүлэх талаарх асуудал,
- Компанийн нэрэнд өөрчлөлт оруулах асуудал
- Хянан шалгах зөвлөлийн тайлан,
- Бусад.

Холбоо барих утас:

99022672, 99096318

Хурал зохион байгуулах комисс

БААЗ (Монголия Инфрастракча) хувьцаа эзэмшигчдийн анхааралд

БААЗ (Монголия Инфрастракча) ХК-ийн 2010 оны ээлжит хувь нийлүүлэгчдийн хурал 2010 оны дөрөвдүгээр сарын 28-ны өдрийн 10.00 цагт Сүхбаатар дүүргийн Жамъян гүний гудамжинд байрлах дэх "Гранд оффис" төвийн наймduгаар давхрын 82 тоот хурлын танхимд хуралдаа болсон тул нийт хувь нийлүүлэгчдийг хуралдаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

Бүртгэх өдөр:

2010 оны гуравдугаар сарын 15

Хэлэлцэх асуудал:

- Компанийн 2009 оны санхүүгийн тайлан,
- 2010 оны ажлын төлөвлөгөө, үйл ажиллагааг идэвхжүүлэх, өргөжүүлэх талаар авах арга хэмжээ,
- Хянан шалгах зөвлөлийн тайлан,
- Бусад.

Харилцах утас:

99183330, 99095066

Хурал зохион байгуулах комисс

"Буян" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

"Буян" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2010 оны дөрөвдүгээр сарын 30-ны өдрийн 10.00 цагт Мэдээлэл технологийн үндэсний паркийн хурлын зааланд болно.

1. Компанийн 2009 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар

2. Компанийн хэлбэрийг өөрчилж ХХК болгох

3. Төсөл батлах

4. Бусад

Бүртгэх өдөр:

2010 оны гуравдугаар сарын 29-ний өдрөөс эхлэн явагдана

Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй БДК-иудаас авч танилцаж болох бөгөөд хурал зохион байгуулах комиссын 96677116, 315582 тоот утсаар ажлын өдрийн 09.00-18.00 цагийн хооронд лавлана уу.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

СУРТАЛЧI

“ХАЙ БИ ОЙЛ” ХК-ИЙН ЗҮЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“ХАЙ БИ ОЙЛ” ХК-ИЙН хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2010 оны дөрөвдүгээр сарын 10 одрийн 17.00 цагт Улаанбаатар хотод “БидиСЕК” ХК-ИЙН байранд болно.

ТГЭХ ӨДӨР: 2010 оны гуравдугаар сарын 26-ны өдрөөс эхлэн явагдана

ЭЛЦЭХ АСУУДАЛ:

Компанийн 2009 оны үйл ажиллагааны тайлан, Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн үйл ажиллагааны тайланд өгөх дүгнэлт

Компанийн Хянан Шалгах Зөвлөлийн мэдээлэл, дүгнэлт 2010 оны ажлын төлөвлөгөө

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох

Хянан Шалгах Зөвлөлийн гишүүдийг сонгох

ТУЗУЛОН ХШЗ-ИЙН 2010 оны зардлын төсөв батлах

Компанийн засаглалын таван журмыг батламжлах

Бусад

Хурал зохион байгуулах комисс

Хурал зохион байгуулах комиссын дарга: С. Бат-Амгалан Утас: 9909-1483
Электрон шуудан: sbatamkan@yahoo.com

Хурал зохион байгуулах комиссын гишүүд: Д.Тогосбаатар Утас: 9969-5847
Электрон шуудан: d_tgsblr@yahoo.com
Э.Баярмаа Утас: 9910-5646
Электрон шуудан: bayarmaae@gmail.com

Хувьцаа эзэмшигчид та бүхэн хурлын материал, санал авах хуудсыг хурал болохоос 15 гийн өмнө өөрийн үйлчлүүлдэг Брокер дилерийн компаниудаар болон “Хай Би Ойл” ийн оффис дээрээс ирж авна уу.

“Монгол Шинэс” (Монголбаниер) ХК-ИЙН Хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Монгол Шинэс” (Монголбаниер) ХК-ИЙН хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлыг 2010 оны дөрөвдүгээр сарын 28-ний өдрийн 10.00 цагт, Улаанбаатар хот, Сүхбаатар үүрэг, Жамъянгүний гудамж-12, “Гранд оффис” төвийн б.2 тоот хурлын танхимд тийхээр болсон тул нийт хувьцаа эзэмшигч түүхийн бүхий хувь нийлүүлэгчдийг хуралдаа дэвхитэй оролцохыг урьж байна.

Бүртгэх өдөр: 2010 оны гуравдугаар сарын 16

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2009 оны санхүүгийн тайлан,
2. 2010 оны ажлын төлөвлөгөө, үйл ажиллагааг өргөжүүлэх талаарх асуудал,
3. Компанийн нэрэнд өөрчлөлт оруулах асуудал
4. Хянан Шалгах Зөвлөлийн тайлан,

БААЗ (Монголия Инфрастракча) Хувьцаа эзэмшигчдийн анхааралд

БААЗ (Монголия Инфрастракча) ХК-ИЙН 2010 оны ээлжит хувь нийлүүлэгчдийн хурал 2010 оны дөрөвдүгээр сарын 28-ний өдрийн 10.00 цагт, Сүхбаатар дүүргийн Жамъянгүний гудамжинд байрлах дэх “Гранд оффис” төвийн наймдугаар давхрын 82 тоот хурлын танхимд хуралдаа болсон тул нийт хувь нийлүүлэгчдийг хуралдаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

Бүртгэх өдөр:
2010 оны гуравдугаар сарын 15

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2009 оны санхүүгийн тайлан,
2. 2010 оны ажлын төлөвлөгөө, үйл ажиллагааг идэвхжүүлэх, өргөжүүлэх талаар авах арга хэмжээ.
3. Хянан Шалгах Зөвлөлийн тайлан,
4. Бусад.

ЗОХИОН ЛЗОЛ

Ин тодорхойлолт;
г баримт;
у чанарын тодорхойлолт;
“сэн загвараар оёж ирүүлж

У Уралдаанд ирүүлэх дөрөвдүгээр сарын 23-ны Улаанбаатар хот, Чингэлтэй үзвүүн гудамж-6, Татварын тоот өрөөнд зохиогч буюу эн төлөөлөгчөөс хүлээн

Уралдаанд ирүүлсэн ын Ерөнхий газрын даргын ан ажлын хэсэг хянан үзэж ид ирүүлсэн материалыг

Эн бүтээлийг дараах байр

- 1. 300 000 төг
- 2. 200 000 төг
- 3. 100 000 төг
- 4. Гурав. Дурсгалын зүйлс

Н УРАЛДААН

Ин ерөнхий газарт ирүүлнэ. Игаруулалтыг дөрөвдүгээр хийнэ.

ЭМЖЭЭ: А4 хэмжээний плүүгүй хуудсанд багтааж, бичгийн дүрмийг баримталж

Ит: Уралдаанд ирсэн байр эзлүүлнэ.
Эг. 150 000 төг
Эг. 100 000 төг
Чэг. 50 000 төг
Чайр. Тав. Дурсгалын зүйлс анд оролцсон сурагч бүрт гардуулна.
Эн зохион бичлэгээс сонгон яж, “Татварт хүүхэд бидний хэвлүүлэн, нийтэд зориулсан эрэглэнэ.

Ү БОЛЗОЛ

Вих шаардлага: YTA-ны иллаганаа чиглэл, бодлого орхойлсон, хууль эрх зүйн унлаг татварын алба” гэсэн н чанар, ач холбогдлыг эл дэвшүүлсэн нийтлэлийн сон байх

Хэмжээ: Times New Roman эр бичигдсэн, A-4 хэмжээний